

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ  
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС  
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
<b>Үүрэг даалгавар НЭГ:</b> Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Газрын зөрчил арилгах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/321 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж, гарааш чөлөөлсөн талбайг тохижуулах ажлыг эрчимжүүлэх.				
1	<p>Нийслэлийн хэмжээнд 2023 оны газрын зөрчил арилгах арга хэмжээний хүрээнд 12 байршлын 852 м2 төмөр хашаа, хайс, 5 байршилд 29 тоосгон гарааш буулгахаар бэлтгэл ажлыг хангаад байна.</p> <p>Зөвшөөрөлгүй 29 тоосгон гарааш эзэмшигчид 2 удаагийн шаардах хуудсыг 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр, 03 дугар сарын 30-ны өдөр тус тус хүргүүлсэн.</p> <p>Дүүргийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/124 дүгээр захирамжаар нутаг дэвсгэрт газрын зөрчил арилгах Дэд ажлын хэсэг байгуулагдсан.</p> <p>Дэд ажлын хэсэг нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчиж нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, авто зам болон явган хүний замыг хааж зохих байгууллагын зөвшөөрөлгүйгээр дур мэдэн барьсан, байрлуулсан хашаа, хайс, хаалт, автомат хаалт, тусгаарлах шон, гинж, автомашины гарааш, зөөврийн байгууламжийн зөрчлийг арилгаж, газар чөлөөлөх ажлуудыг гүйцэтгэж байна.</p> <p>Дүүргийн хэмжээнд 2023 онд газрын зөрчил арилгаж, газар чөлөөлөх байршлын төлөвлөгөөг Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны “Кадастрын хэлтэст хүргүүлсэн.</p> <p>Тус байршлуудад тохижилтын ажлыг гүйцэтгэхээр зураг төсвийн ажлуудын судалгааг хийж гүйцэтгэж одоогийн байдлаар геодезийн хэмжилтийн ажил хийлгүүлэн, Захирагчийн ажлын алба, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ болон Нийслэлийн хөрөнгө оруулалтын газруудад тус тус судалгааг хүргүүлсэн.</p>			30
<b>Үүрэг даалгавар ХОЁР:</b> Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/242 дугаар захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, аж ахуйн нэгж байгууллагуудад барилгын чанар, стандартын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллах.				
2	<p>Дүүргийн хэмжээнд 17 барилга шинээр баригдаж, 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар 11 барилга угсралтын ажлыг эхлүүлж, 6 барилга ажлаа эхлүүлэх бэлтгэл ажлыг хангуулж байна. Стандартын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавих ажлын хүрээнд барилгын нэгдсэн мэдээллийн судалгааг Сууц өмчлөгчдийн холбоодод албан бичгээр хүргүүлэн ажилласан. Авто зам, явган зам, гэрэлтүүлэг, хашаа хайс, тоглоомын</p>			70

	<p>талбай, хогийн цэгүүдийн зөрчлийн мэдээллийг 1-24 дүгээр хороод тус бүрээс авч нэгтгэн Хотын стандарт хяналтын газарт хүргүүлэхээр бэлтгэн ажиллаж байна.</p> <p>Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилтын хүрээнд нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, норм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/242 дугаар захирамжийг Хотын стандарт, хяналтын газрын дарга С.Төмөрдулам 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газар, 1-24 дүгээр хороодын Засаг дарга нар зэрэг холбогдох нийт 56 албан хаагчдад танилцуулан сургалт хийсэн. Тус захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн “Ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон үйл ажиллагааны удирдамж батлах тухай” А/120 дугаар захирамжаар “Иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай орчныг бүрдүүлэхэд хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах тухай” нэгдсэн удирдамж батлагдсан. Удирдамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр нийслэлийн Хотын стандарт, хяналтын газар, дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран дүүргийн 5 дугаар хороо Бишрэлт зочид буудлын хурлын танхимд хүнс, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нийт 231 иргэн, аж ахуйн нэгжид худалдаа үйлчилгээний байгууллагын гадна орчны стандарт, хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар сургалт зохион байгуулав.</p>			
<p><b>Үүрэг даалгавар ГУРАВ:</b> Нийслэлийн хэмжээнд ногоон байгууламжуудыг нэмэгдүүлэх, мод тарих, ургуулах, төгөлжүүлэх, арчлах, зүлэгжүүлэх, мөн харшлаас сэргийлж /Шарилж/ хогийн ургамлыг устгах, модны хөвөн хийсэхээс урьдчилан сэргийлэх ажлуудаа зохион байгуулах.</p>				
3	<p>Монгол улсын Ерөнхийлөгчийн “Тэр бум мод” хөтөлбөрт уялдуулан дүүргийн хэмжээнд мод тарих ажлын хүрээнд 10.000 мод тарихаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран ажиллаж байна. Тус ажлын хүрээнд “Хайрхан хөгжлийн төв”, “Хоймор хайрхан” амралтын газарт модны нүх ухах, усалгаа арчилгаа хийх ажлуудыг 2023 оны 05 дугаар сарын 13-ны өдөр эхлүүлэхээр төлөвлөн нээлтийн өдөрлөгийг зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж ажиллана.</p> <p>Нийтийн эзэмшлийн зам талбайн цэнэг усалгаа эхэлсэн ба хэлбэржүүлэх ажлыг Чингэлтэй дүүргийн “Тохижилт Үйлчилгээ” ХХК-тай хамтран зохион байгуулан ажиллаж байна.</p>			70
<p><b>Үүрэг даалгавар ДӨРӨВ:</b> “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг шинэлэг хэлбэрээр зохион байгуулах бэлтгэл хангах.</p>				
4	<p>“Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тэмдэглэх ажлыг зохион байгуулах Ажлын хэсгийг Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/143 тоот захирамжаар баталсан.</p> <p>Захирамжийн дагуу Ажлын хэсэг дараах 3 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Дүүргийн “Хүүхдийн зөвлөл”, “Хүүхдийн-элч”, зөвлөлийн гишүүд 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр хуралдана.</li> <li>➢ Фото булан ажиллуулах (Оролцогчдын зургийг авч дурсгал болгон өгөх, frame аялуулах)</li> </ul>			70

	<ul style="list-style-type: none"> <li>➤ “Талархалын мод” арга хэмжээ (Үйл ажиллагаанд оролцогчид нэг нэгэндээ хэлмээр байгаа үгсийг бичиж бэлтгэсэн буланд наах)</li> </ul>			
<b>Үүрэг даалгавар ТАВ:</b> Ерөнхий боловсролын сургуулийн орчинд хүүхдийг дээрэлхэж, эд зүйлсийг дээрэмдэх, хулгайлах, танхайрах зэрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд онцгой анхаарч ажлаа эрчимжүүлж, газар дээр нь тавих хяналтыг нэмэгдүүлэх.				
5	<p>Дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын орчинд хүүхдийн эрхийн зөрчил, гэмт хэрэг гарах нөхцөл байдлаас урьдчилан сэргийлж дараах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Нийслэлийн Боловсролын газрын хүүхдийн эрх, хөгжил хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Мөнх-Эрдэнэ “Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх”</li> <li>➤ Нийслэлийн Хөвгүүдийн зөвлөлийн зохицуулагч Ч.Адъяатөмөр “Үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг бидний дуу хоолой”</li> <li>➤ Цагдаагийн ерөнхий газар, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн мэргэжилтэн цагдаагийн дэслэгч Б.Анура “Хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь”,</li> <li>➤ НЕБ-ын 72 дугаар сургуулийн нийгмийн ажилтан Г.Ууганцэцэг “Сургуулийн орчин дахь үе тэнгийн дарамт дээрэлхэлтийг бууруулах сайн туршлага” гэсэн сэдвийн хүрээнд мэдээлэл, зөвлөгөөг дүүргийн 12 сургуулийн давхардсан тоогоор 1400 сурагчдад хүргэсэн. Дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын эцэг эхчүүд “School police” эргүүлийн ажлыг сургуулийн ойр орчмын авто замын гарц дээр байнга гүйцэтгэн хүүхдүүдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, гэмт хэрэг гарч болзошгүй тоглоомын талбай, саравчаар эргүүл, хяналтыг тогтмол гүйцэтгэж байна. Сургуулиудын тухайн өдрийн жижүүр багш, нийгмийн ажилтнууд хараа хяналт тавин ажиллаж байна.</li> </ul>			100
<b>Үүрэг даалгавар ЗУРГАА:</b> Сургуулийн орчинд элс, хайрга, дайрга ачсан хүнд машин механизмын техникийн бүрэн байдал болон замын хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавьж, хүүхдийг зам, тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлж ажиллах.				
6	<p>Урин дулааны улирал эхэлсэнтэй холбогдуулан сургуулийн ойр орчимд барилга, газар шорооны ажил эрхэлж байгаа аж ахуй нэгж байгууллага, барилгын талбай орчимд хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэн, “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598: 2020”, “Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 3-р хавсралтаар хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгсэл нь Монгол Улсын нутаг дэвсгэрт мөрдөгдөж байгаа тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавигдах үндсэн шаардлагуудыг хангасан байхаас гадна зам талбай бохирдуулахгүй байх гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулан тогтмол хяналт шалгалт явуулж ажиллалаа. Гудамж, замын хяналт шалгалтаар нийт 825 тээврийн хэрэгслийг шалгаж:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Монгол Улсын “Зөрчлийн тухай хууль-н 14.7.15-д заасны дагуу 260 жолоочийг 5.200.000 төгрөгөөр /таван сая хоёр зуун жаран мянга/</li> <li>➤ 14.5.17-д заасны дагуу 9 жолоочийг 1.350.000 төгрөгөөр /нэг сая гурван зуун тавин мянга/,</li> <li>➤ 14.6.5-д заасны дагуу 193 жолоочийг 3.860.000 төгрөгөөр /гурван сая найман зуун жаран мянга/,</li> </ul>			100

	<p>➤ 14.7.10.2-т заасны дагуу 43 жолоочийг 2.150.000 төгрөг /хоёр сая нэг зуун тавин мянга/ нийт 505 жолоочид 12.560.000 /арван хоёр сая таван зуун жаран мянга/ төгрөгийн торгуулийн арга хэмжээ тус тус тооцон, 15 тээврийн хэрэгслийн бичиг баримтыг түр хураан авч зөрчлийг арилгуулан ажилласан.</p> <p>Дүүргийн ЕБС-иудын тухайн өдрийн жижүүр багш, "School police"-н үүрэг гүйцэтгэж буй эцэг эхчүүд замын хөдөлгөөнд орж буй авто машин, явган хүний гарцад зохицуулалтыг тогтмол хийж байна.</p> <p>Хүүхдийг зам, тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 56 дугаар цэцэрлэг, ЕБ-ын 17, 72 дугаар сургуулийн хажуу болон урд талын авто замын дагуу 150 метр урттай хашлага хийсэн.</p>			
<p><b>Үүрэг даалгавар ДОЛОО:</b> Авто замын засвар шинэчлэл, нөхөөс, тэмдэг, тэмдэглэгээг будах, явган хүний гарц, цагаан шугамыг угаах зэрэг ажлуудаа эрчимжүүлэх.</p>				
7	<p>Дүүргийн 9 дүгээр хороо 39-р сургуулийн өмнөх дугуй засвараас Дэнжийн-1000, "Хүчит шонхор" захын баруун талын замыг 4 эгнээ болгож өргөтгөх авто замын засвар шинэчлэлийн ажил эхэлсэнтэй холбогдуулан замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.</p> <p>Дүүргийн нутаг дэвсгэрт гудамж, замд эвдэрсэн хонхорхой үүссэн замын судалгааг "Улаанбаатар зам засвар, арчлалтын газар"-т мэдэгдэж нөхүүлэх ажлыг зохион байгуулсан. Шинээр нөхөж байрлуулах тэмдэгтүүдийн судалгааг гаргаж "Замын хөгжлийн газар"-т хүргүүлэн ажилласан.</p> <p>Дүүргийн 1-24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт явган хүний гарцын 5.19 /а,б/ тэмдгийг 25 байршилт 34 ширхгийг шинээр байрлуулан, зорчих хэсгийн тусгаарлах зурвас, явган хүний гарцын тэмдэглэл арилсан, муудсан, будах шаардлагатай газруудын судалгааг шинэчлэн гаргаж байна.</p> <p>Дүүргийн "Чингэлтэй Төхижилт үйлчилгээний компани"-тай хамтран нутаг дэвсгэрт байрлах хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл, авто замын тэмдэг, тусгаарлах хайсыг угааж, цэвэрлэх ажлыг зохион байгуулж өнгө үзэмжтэй болгон ажиллаж байна.</p>			70
<p><b>Үүрэг даалгавар НАЙМ:</b> Зуслангийн бүсэд байгаа айл өрхүүдийн нүхэн жорлонгуудыг ариутгах, халдваргүйжүүлэх, ашигтай бактер хийх ажлаа эрчимжүүлэх.</p>				
8	<p>Дүүргийн нутаг дэвсгэр дэх зуслангийн бүсэд байгаа айл өрхүүдийн нүхэн жорлонгуудыг ариутгах, халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулахаар 19, 24 дүгээр хороодод суурь судалгааны ажлыг хийж гүйцэтгэж байна.</p> <p>Ариутгал халдваргүйжүүлэх ажлын зардлуудыг төсвийн төсөлд суулгах санал хүргүүлэхээр төлөвлөн, боловсруулан ажиллаж байна.</p> <p>Төсвийн тодотголд санал хүргүүлж, төсвийн зардал суусны дараагаар гүйцэтгэгч компанийг шалгаруулж ажлуудыг зохион байгуулахаар төлөвлөсөн.</p>			

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА Л.БАЯРМАА

ХЯНАСАН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
ДАРГА Н. НАРАНЗУЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Э.ХУЛАН

НЭГТГЭСЭН:  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН Т.ТҮВШИНЖАРГАЛ